

КИПЧАК АЙМГИЙН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛД [ОРСОН] КИМЕК, ИЙМЭКҮҮД

Петер Б. Голден.

Ратжерс Их сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлд манай тооллын VIII-X зууны эх хүртэл баруун Сибирьт сууж байсан Кимакийн үүсэл гарлыг тодруулан авч үзлээ.

Түлхүүр үг: Кимак, Арба Перс газар зүйн зохиолууд, отуз татар, есөн татар, лалын сурвалжууд.

Урт хугацааны турш *Иймэк/иймэк* [*Yimek/Yemek*] нь *Кимек* [*Kimek*]¹ хэмээх Баруун Сибирьт (м.т. 750-800- XI зууны эхэн хүртэл) төвлөрч байсан аймгийн холбооны нэрийн нэг хэлбэр гэж үзэж байлаа. Понто-Каспий-Ижил-Урал-Казакстаны тал нутагт Кипчак аймгийн холбоо ноёлох бүрдэл болох үед алдарт *Дешт-и Кипчак* [*Dasht-i-Qipchaq*], Иймэк, Иэмэк нь түүхийн сурвалжуудад тогтвортой дурьдагдах болжээ². Гэсэн хэдий ч Кашгарын Махмуд [*Mahmud al-Kashghari*] (1077 онд туурвисан бүтээлдээ) Кипчак, Иймэк/Иэмэк хооронд нь ялгаж байсан байна. (Түүний амьдарч байсан үед Кимак хэмээх этноним хэрэглээнээс гарч аймгийн холбоонд Кипчак ноёлох байр суурийг олсон байв). "Иэмэк нь түрэг аймаг [байна]. Бид нар тэднийг түрэг гэж үзэж, харин түрэг Кипчак тэднийг ондоошуулан ойлгож байв"³. Кашгарын Махмуд түрэг хүмүүсийн товчоондоо Кипчакийг Иймэк хооронд, тусад нь Огузыг оруулсан байна⁴. Эдгээр тэмдэглэл нь угсаа гарлын ялгаатай ухамсрын чухал илрэл юм. Хэлний аргаар Кашгар (Киргиз, Огуз, Тугши, Яагмаа, Чигил, Ограг ба Чарукийг цэвэр түрэг нэг хэлээр ярьдаг гэж үзэж) мөн "Иймек ба Башкирт" нарыг тэдэнд "ойр"⁵ гэжээ. Иймекууд тэр үед Иртыш мөрний зүүн эрэг хавиар "Иймекийн тал"⁶ гэж нэрлэж байсан нутгаар нутаглаж байсан дүр зураг бууж байна. Кашгарийн мэдээг үндэслэн Хасан Эрэн [*Hasan Eren*] тухайн үед "Кимак хэмээх нэр нь... ач холбогдлоо алдаж, Иймэк хэмээх салаа аймгийн нэр орлон гарч ирсэн байна" гэжээ. Тэрбээр Иймэкийг Кимактай холбоотой Иэмэкийн хоёрдагч хөгжил гэж авч үзжээ⁷.

Иймэк /Иэмэк нь Кимектай ямар харилцаатай байв? Тэд нар Кипчактай ямар холбоотой байсан байна? Кимак, Имэк, Иймэк, Иэмэк аль аль нь Орхоны Түрэг, эсвэл Уйгур бичээст дурьдагдаагүй байна. Үнэн хэрэгтээ Кипчакийг төлөөлөл нь (Уйгурын Эльтэтмыш Билгэ хааны бунхан цогцолборын [747-759] нэг хэсэг 740 оны үеийн үйл явдлыг тусгасан Шинэ усны) нэгэн бичээст тусгасан байх магадлалтай гэвч эл асуудал маргаантай хэвээр үлдэж байна. Тэдний нэрийг тухайн бичээсийн эхний хувилбараар

¹ It is my pleasant obligation to note that much of the research and writing of this paper was carried out while on a fellowship from the U.S. National Endowment for the Humanities in 2001.

² On these tribes see Golden, "Cumanica IV: The Tribes of the Cuman-Oipcaqs" *АЕМАе*, 9 (1995-1997), pp. 99-122; B. E. Kumekov, "Ob etnonimii kypchakskoi konfederatsii zapadnogo Desht-i Kypchaka XII-nachala XIII v." *Izvestiia natsional'noi Akademii Nauk Respubliki Kazakhstan*, ser. obshestvennykh nauk(1993), No. 1, pp.58-70.

³ Mahmiid al-Kasgari, *Compendium of the Turkic Dialects (Diwan Lugat at-Turk)*, ed, trans. R. Dankoff in collaboration with J. Kelly (henceforth: *Kashghari/Dankoff*, Cambridge, Mass., 1982-1985), II, p. 161

⁴ *Kashghari/Dankoff*, I, p. 82. Mubarakshah (writing before 1206. see *Tirikh-i Fakhruid-Din Mubarakshah*. ed. E. Denison Ross, London, 1927, p. 47, places the Yemek in his listing of Turkic peoples next to the Turks, Qirghiz and Qarluq. Elsewhere, he notes the Kimek. If this is not simply a Jumbling of several sources. It would again point to a separate existence for the Kimeks and Yemeks.

⁵ *Kashghari/Dankoff*, I, p. 83

⁶ *Kashghari/Dankoff*, I, p. 129 and his "Three Turkic Verse Cycles Relating to Inner Asian Warfare" *Harvard Ukrainian Studies*, III-IV (1979-1980), p. 153, although Dankoff has some doubts about Kashghari's geographical data.

⁷ H. Eren, "Kimek ve Imek Boy Adlary Hakkinda" *Turk Dili Dergisi*, IV/45 (Haziran, 1955), pp. 541-543.

нөхөн сэргээсэн боловч бичээсийн зөвхөн нэг хэсэг нь хэвээр хадгалагдан үлдсэн бөгөөд асуудалтай шугамын уншигдсан ихэнх хэсэг бараг арилсан байна⁸. Руни бичигт дурьдагдах Чиктай [Chik] Кимакийг⁹ холбох оролдлогууд нь газар зүйн хэтрүүлэг дээр үндэслэсэн дам яриа төдий юм.

IX-X зууны Араб, Перс түүх, газар зүйн сурвалж болон өмнөх үед бичсэн цуглуулсан материал дээр үндэслэн хожуу үеийн сурвалжуудад ер нь Кимек этноним, [kɒmɛk=kimɛk/kimek] олон янзаар тэмдэглэгдэж, Лалын сурвалжуудад түрэг хүмүүсийн тухай хамгийн эртний жагсаалтанд орсон байна. Ибн Хурдадби [Ibn Khurdadhbih] (820-912, 880 оны үед бичихдээ) Тамим б.Баар [Tamim b. Baar] (тэрбээр 820-иод оны үед Уйгурт аялсан)¹⁰ мөн Түрэг нутгаар 840-өөд оны үед аялсан орчуулагч Салам¹¹ нарын бүтээл дээр үндэслэн "Токуз огуз зүүн талд" тэднийг байрлуулж, Карлук, Огуз, Чакир (?), Печенег, Түргиш, Адкиш, Кипчак (Кифшак) ба Киргиз зэргээс бүрдсэн Түрэг бүлэглэлд оруулсан байна¹². Энэ тэмдэглэл нь магадгүй Лалын газар зүйн зохиолд гарч ирж буй анхны тохиолдол юм.

Эртний Кимекийн түүх, үүсэл ба он тоолол судлагдаагүй хэвээр байна. Аль Яакуби [Al-Ya'qubi] (X зууны сүүл XI зууны эхэн үед бичиж байсан) "Туркастан" хэмээх зохиолдоо "түрэг [аймгууд] олон тооны ай (ajnes) ба олон улсаас бүрдсэн байна (mamelik мамаликийг бас "вант улс" буюу "улс" гэж буулгаж болно). Үүнд: Карлук, Токуз Огуз, Түргиш, Кимек ба Огуз байна"¹³ гэжээ. Хожим нь он Ок [on Oq] /баруун Түрэгийн ноёлох бүрдэл болж, 766 онд Карлукт шахагдан хорь гаруй жилийн дараа тухайн бүс нутагт нэвтрэн оржээ. Огуз нар Трансоксанид 770-ад оны үед орж ирсэн байна. Энэ хоёр [аймаг] Төв Азийн баруун хэсэг рүү Уйгурын дарамтаас зайлан нүүдэлжээ¹⁴. Түрэгтэй бага зэрэг цаг хугацааны ташааралтай байгаа хэдий ч Ибн Хурдадби болон энэхүү тэмдэглэл нь Кимек нар VIII зууны сүүлийн мөчлөгт оршин тогтнож байсныг илрэл юм¹⁵. IX зууны Лалын товчооны мэдээ хожуу үеийн IX, X, XI зууны Араб, Перс газар зүйн зохиолуудад [Кимек нэр] хадгалагдан үлджээ. Тутуг/Tutugh (totog<Хятад tu-tu, Дундад [үеийн] Хятадын tou-tok цэргийн жанжины¹⁶ >) хэргэмтэй манлайлагчийн хэргэмтэй гардаг бөгөөд хожим аанай өндөр хэргэм Ийнал яабхүү [Ynnal Yabghu]-аар өргөмжилсөн байдаг¹⁷. Өөр нэг сурвалжид энэхүү

⁸ See T. Moriyasu & A. Ochir, *Provisional Report of Researches on Historical Sites and Inscriptions in Mongolia from 1996 to 1998* (Osaka, 1999), pp. 178-179. See reconstructed reading in G. Aida-rov, *Iazyk orkhonskikh pamiatnikov drevnetiurkskoi pis'mennosti VIII veka* (Alma-Ata, 1971), p. 344.

⁹ See F. Sumer, *Oguzlar*, 3rd ed. (Istanbul, 1980), p. 31.

¹⁰ V. F. Minorsky, Tamim b. Bahr's Journey to the Uyghurs" *Bulletin of the School of Oriental and African Studies*, 12 (1948, hence forth: Tamim/Minorsky), pp. 417-437.

¹¹ P. J. Bulgakov, "Kniga putei i gosudarstv Ibn Khordadbekha" *Palestinskii Sbornik*, vyp. 3 (66) (1958), pp. 127-136; I. Ju. Krachkovskii, *Arabskaia geograficheskaia literatura in his Izbrannve sochineniia* (Moskva-Leningrad, 1955-1960), IV, pp. 137-141.

¹² Ibn Khurdadhbih, *Kitab al-Masalik wa'l-Mamalik*, ed. M. J. de Goeje (Leiden, 1889), p. 31.

¹³ Al-Ya'qubi, *Kitab al-Buldan*, ed. M. J. de Goeje (Leiden, 1892), p. 295.

¹⁴ P. B. Golden, "The Migrations of the Oguz" *Archivum Ottomanicum*, P. B. Golden, "The Migrations of the Oguz" *Archivum Ottomanicum*, IV (1972), pp. 45-84.

¹⁵ Another view may be seen in S. M. Akhinzhanov, "Etnogeneticheskie protsessy na territorii Kazakhstana v kontse I tysiacheletia n. e. (Kimaki i Kypchaki)" in B. A. Litvinskii and T. A. Zhanko (eds.), *Problemy etnogeneza i etnicheskoi istorii i narodov Srednei Azii i Kazakhstana*, vyp. Istoriia i arkheologiiia (Moskva, 1990), p. 108, who interprets Tamim b. Bahr's location of the Kimek "to the left of the Toquz Oghuz" as indicating a habitat in Northeast Mongolia in the early ninth century.

¹⁶ Sir Gerard Clauson, *An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish* (Oxford, 1972), p. 453.

¹⁷ Gardizi, Ta'rikhi-i Gardzi, ed. 'Abd al-Hayu Habibi (Tehran, 1363/1984), pp. 551, 554, see also V. V. Bartol'd (Barthold), "Izviechenie iz sochineniia Gardizi *Zain al-Akhbar*" [henceforth: Gardizi/Barthold] in V. V. Bartol'd, *Sochineniia* (Moskva, 1963-1977), VI-II, Pers. pp. 27, 28/Russ. trans, pp. 44, 45. An English translation of this important text may be found in A. P. Martinez, "Gardizi's Two Chapters on the Turks" [henceforth:

манлайлагчийг "ван" [*king*]¹⁸ гэж заасан байдаг. Бас нэг найдвартай сурвалжид хаан/хаган [*qaghan*] буюу талын [нүүдэлчдийн] ертөнцийн хэмжээнд эзэн хаанаар дурьдсан байдаг¹⁹.

Энэхүү хүмүүсийн түүхийг судалдаг цөөн хэдэн хүмүүсийн нэг, Кумеков Кимекийг Баруун Түрэг / Он Ок улсын хамжилгат аймаг гэж авч үзсэн байдаг. Лалын газар зүйчдийн хараанд ороход хойт хөрш болох Карлук болон Огуз нарыг үе үе заналхийлдэг амаргүй [аймаг] гэж Кимекийг үзсэн байдаг. (X зууны эхний хагаст бичиж байсан) Аль Ма'суди [*Al Ma'sudi*] эл гурван аймгуудын хооронд дайсагнал байгааг дурьдаад, тал нутагт суурьших боломж өгөхгүй бусад Түрэг угсааны аймгуудыг өөр бүс нутагт нэвтрэхэд хүргэжээ гэж Аль Ма'суди үзжээ²⁰.

VIII зууны хоёрдугаар хагас болон IX зуунд Кимекүүд төрийн институт ба төр байгуулахад иймэрхүү дайны ажиллагаа явуулахад хүргэсэн гэж Кумеков нотолж байгаа юм²¹. Миний үзэж байгаагаар, Лалын орнуудад гаргаж байсан умардын гол бараа болох ангийн үсний худалдаанд Кимекууд оролцож байсан нь тэдний төрийн төлөвшилд чухал хурдасгуур болжээ²². Үнэндээ, тэдэнд хүрэх замыг нээсэн болон газар нутгийн талаар тайлбар хийсэн лалын худалдаачдад бид талархах ёстой бөгөөд дээр дурьдсан зүйл тэдний анхаарлыг татсан байна. Хааны хэргэмээс гадна, төрт ёсгүй Түрэг аймгуудын их зонхи ертөнцөд ер бусын байдал ажиглагдсан байна. Кимекууд өөрийн нийслэл хоттой (*nmkiy-ya*), Иймакийн нутаг дэвсгэр дээр байрласан *Иймакия/Ямакия* (*Yimakiyya /Yamakiyya*) гэгдэх нийслэлтэй байсан бололтой. Худудын үйлдсэн сурвалжид Кимакийн хаан арван нэгэн "шадартай" байсан ба тэд удамшлан залгамжлагдах "зэмшил" (*a'mal*)-тэй²³ байсан байна. Энэхүү эртний улс нилээд урагшаа ахисан засаглалын байгууллага болон "феодал" бүтэцтэй байсан нь илэрхий байна.

Кимакийн үүслийн үлгэр

XI зуунд Гардизигийн бүтээсэн алдарт бүтээл нь Кимакийн үүслийн тухай хамгийн чухал сурвалж юм. Энэ сурвалж, өмнө нь 770-840 оны хооронд бичигдсэн сурвалжийн мэдээнд үндэслэн, манай тооллын 745-770 онуудын үйл явдлыг тайлбарласан байдаг. Энэхүү сурвалж XV зууны сүүл -XVI зууны эхээр Кембриджийн Кингз коллежийн 213 [данс] болон 1781 онд бичигдсэн Оксфордын Бодлеиан Оуслей нь 240 [данс] зэрэг Энэтхэгээс олж авсан хоёр гар бичмэлээр уламжлагдсан сурвалж байна²⁴. Бидний эрхлэж буй судалгаанд нэн шаардлагатай "харь" нэрсийн олонхи нь "аймшигтай" эвдэгдсэнийг энд тэмдэглэх илүү буй заа. Энэ сурвалжийн дагуу "тамарын манлайлагч" (*mihtar-i Tateren*) нас барахдаа хоёр хүү үлдээжээ. Бага

Gardizi/Martinez] *Archivum Eurasiae Medii Aevi*, II (1982), pp. 109-217, including facsimiles of the Cambridge ms. The section on the Kimek is found on pp. 120-123.

¹⁸ Tamim/Minorsky, " Arabic, p. 281/Eng. Trans. p. 284; Ibn al-Faqih, Mashhad ms., f. 16Sa, cited in B. E. Kumekov, *Gosudarstvo Kimakov IX-XI vv. po arabskim istochnikam* (Alma-Ata, 1972), p. 116; al-Idrisi, *Kitab Nuzhat al-Mushtaq fi Ikhtiraq al-Afaq: Opus Geographicum sive "Liber ad eorum delectationem qui terras peragrare student*, ed. A. Bombaci et al. (Napoli-Leiden-Roma, 1970-1984), p. 520.

¹⁹ *Hudud al-'Alam*. ed. M. Sotodeh (Tehran, 1340/1962), p. 85, Eng. trans. V. F. Minorsky, *Hudud al-'Alam. The Regions of the World* (London, 1937, reprint with additions. 1970), pp. 99-100.

²⁰ Al-Mas'adi, *Kitab at-Tanbih wa'l-Ishraf*. ed. M. J. de Goeje (Leiden. 1394), pp. 180-181.

²¹ Kumekov, *Gosudarstvo Kimakov*. p. 115ff.

²² Golden, *An Introduction to the History of the Turkic Peoples*, pp. 204-205.

²³ *Hudud al-'Alam*. ed. M. Sotoodeh, p. 85, Minorsky, pp.99-100. Some later texts note a capital "Kimakiyya," see M.K.Kozybaev et al., *Istoriia Kazakhstana s drevneshix vremen do nashikh dnei* (Almaty, 1996), I, pp.328, 345n. 134;

²⁴ See K. Czegledy, "Gardizi on the History of Central Asia (745-780) "Acta Orient alia Academiae Scientiarum Hungaricae", XXVII/3 (1973), pp. 257-267

хөвгүүн Шад (*Shad*)²⁵ төрсөн ахдаа атаархаж, эрх мэдлийг булаах оролдлого хийн бүтэлгүйтсний дараа хайрт боол охинтой (*kapozako*) оргожээ.

Тэрбээр нэгэн их мөрний ойролцоо орогнол олж, түүнийг долоон төрлийн (*muwallden*)²⁶ албат нь байсан байж магадгүй) хүн дагаж очжээ. Эл долоод: Ийми [*iymy*], Иймак [*iymek*], Татар [*tter, tater*], Бландр [*Blendr*], Кфчак [*khfchvq*], Инказ [*inqez*], ба Ижлад [*ijlvd*] зэргийг дурьдсан байдаг. Үүнээс хойш Тутуг гэж нэрлэгдэх болсон Шадад дагаж орох нэг хүчин зүйлд адууны (буюу эзний адууг бэлчих) бэлчээр дутагдсан гэж заажээ. Хожим үл мэдэгдэх дайнаас дүрвэн гарсан амьд үлдсэн татарууд Шадад дагаар орж, тэдний тоо долоон зуу хүрч, түүний албат болсон байна. Энэ домогт долоо долоон аймгийн (*haft qabola*) үндэслэгчид болсон байна. Тус сурвалж Кимекийн газар нутгийн нарийвчилсан зураг, Кимекийн шашин шүтлэгтэй холбоотой үлгэр, туйл болон Иртыш/Эртыш мөрний нэрийн, үүслийн, этимологийн үлгэр зэргийг багтаасан байна. Тутуг [*Tutugh*] (хэргэмийн) нэр (бичвэрт: ... -ийг гэж зассан байна), эртний Түрэг хэлэнд *tutug/totoq* гэнэ. Эн хэсэгт "*ra'is-l osen-re(y) inel yabgy gyuand*" / "тэдний манлайлагчийг Ийнал Яабху гэдэг"²⁷ гэжээ.

Аймгуудын нэрийн дотор зөвхөн татар кипчак тодорхой байна. Иймак гэсэн үг [*Imak*]-ийг төлөөлж болох бөгөөд *Иймэк/Иэмэк* [*Yimek/Yemek*] гэсэн нэр бас бид нарт байгаа билээ. Харин "Иймак" алдаагүй бичсэн хувилбар бол бид энэ үгийг өөрөөр уншиж бас болно, тухайлбал Эймэк, Оймак, Уймак [*Eymek, Oymak, Uymak*] гэх мэтчлэн. Мөн Араб бичигт ялимгүй зассан түгээмэл хэлбэрүүд гарч ирж болно: [*ibmek, itmek, inmek*] зэргийг [*blendr*] бландрийг Бартольд баяндир гэж уншижээ. Энэ нь Огузын Баяндир [*bayndir*] аймгийн нэртэй адилхан харагдаж байгаа боловч ямар нэг холбоогүй болов уу²⁸. Кумеков баяд [*Bayat*], байргу [*bayirgu*]-тай болон Огузын баяндиртай холбож байгаа юм²⁹.

Эдгээр холбоо түүхэн ямар ч үндэслэлгүй байна. Огузын Эймур [*Eymur*] аймгийн нэрийг араб бичвэр [*mwr*]-г Имур гэж уншихыг Маркуарт санал болгосон. Энэ бичвэрийг ийнхүү тайлсаныг Кумеков болон бусад нь дагасан байна³⁰. Түрэгийн хаант улсын үед Байгал нуурын зүүн, зүүн өмнөд хэсэгт амьдарч байсан эл хүмүүсийг Баруун Түрэгийн хаант улстай холбогдуулж бичсэн араб бичиг [*ytn*] *Именыг* [*Imen*] гэж Тору Сенга үзэж, Хятадын *иен-миен* [*Yen-mien*] [Дундад Хятадын [*ien-mian*] харьцуулжээ³¹. Эл үгийг яаж л бол яаж уншиж болохыг энд дахин тэмдэглэе. Үүнтэй төсөөтэйгээр Рашид-ад Дины тэмдэглэсэн араб бичиг үгийг жалайр аймгийн

²⁵ This is an Old Turk title of Iranian origin, Clauson, ED, p. 366

²⁶ *Muwallad* originally denoted the idea of someone born and raised among Arabs, but not of Arab origin, see R. Dozy, *Supplement aux dictionnaires arabes* (Leyde, 1881), II, p. 349, and implied some social inferiority. Gardlii/Barthold, p. 27, reads it: *haft tan az muwalidan-i Tataran*, which he renders as "seven people from his Tatar kinsmen." Martinez/Gardizi, p. 120, suggests *mawaliyan* "clients" or *muwalidan* "adopted, inferior [tribesmen] for *muwalladin*

²⁷ Gardizi, Ed. Habibi. Pp. 550-551 (who has *haman yabgh!* for "(y) inai ybghu"); Gardizi/Batbold. p. (who has *bmal biEhu*), Gardizil/Martinez, pp. 120-123 whose emendation I am following here. Marquart, Komanen. p. 93 suggested *Imak Yabghu*.

²⁸ Gardizi/Barthold. p. 27. Cf. the Oghuz tribe Bayindir, see Sumer, *Oguzlar*, pp. 315-319. Sumer, however (p. 32), does not connect the two.

²⁹ Kumekov, *Gosudarstvo*, p. 44

³⁰ J. Mai-quart, *Über das Volkstum der Komanen* in W. Bang. J. Marquart, *Osttiirkische Dialektstudien. in Abhandlungen der königlichen Gesellschaft der Wissenschaften zu Göttingen, Phil. - hist. Klasse, N. F., XIII* (Göttingen, 1914), p. 96n. 7; Kumekov. *Gosudarstvo*. pp. 37-39. Kumekov takes this a step further and identifies Eymur with the Uyghur *Eyebor/Eyebir* tribe for which there is no basis.

³¹ T. Senga. "Megjegyzesek a kimekek torzsszovetsegének kialakulasa-hoz" *Amik Tanulroanytok*. XLI/1-2 (1997), pp. 186-187; E. Chavanne&, *Documents sur les Tmi-kieue (Turci) Occidentaux* (St. Petersburg. 1903, Paris. 1941). p. 123n. 1; Liu Mau-tsai. *Die chinesischen Nachrichten zur Geschichte der Ost-Tiirken (T'u-k'ue)* (Wiesbaden. 1953), I. p. i28. n, p. 5ti(). F. Altheim. *Geschichte der Huonen* (Berlin, 1959-1962).

Нилган[*Nilqan*]-тай харьцуулж болно³². Ийм засварууд Араб хэлний гар бичмэлд түгээмэл тохиолддог юм. Ямар ч тохиолдолд [л] буюу *n* [н] үсгийг Түрэг гэж үзэж болохгүй юм. Бусад нэрний хувьд асуудал илүү ярвигтай байгаа юм. Одоогийн байдлаар, гэсэн хэдий ч зарим зүйлийг тэмдэглэх нь зүйтэй юм. Нэгдүгээрт, юуны өмнө ядаж тэргүүлэгч овгийнхан буюу овгууд татараас гаралтай байна. Тэд Монгол Манжуурын хил хавийн нутгаар нутаглаж байсан хожмын Монголчууд ажээ. Нэлээд олон тооны угсаатны цогц нутаглаж байсан эл бүс нутаг нь түргийн ертөнцийнхнөөс гадна илүү олон миграцийн эхлэлийг тавьсан байна. Хоёрдугаарт, тэдний удирдагчид Түрэгийн хаант улстай холбоотой хэргэм (эдгээрийн гарал үүслээс үл хамааран) хэрэглэж байжээ. Татарууд Түрэг улсын хараат байсан (токуз татар, отуз татар бүлгүүд Куль тэгины болон Билгэ хааны бичээс дээр КТ, Е1, 14, S1, BQ, E5, 34 зэрэгт дурьдагсан байдаг)³³. Энэ бүх үйл явдал Татар хэмээх этноним олон улсын ач холбогдолтой болохоос өмнө буй болсоныг сануулж байгаа юм. Энэ сурвалжид авцалдаагүй зүйл үгүй бөгөөд Монгол-Манжуурын хил орчмын нутгаас гаралтай болохыг илтгэж байна.

Шинэ усны бичээс Уйгур болон Сэкиз Татар, Карлук, Басмил, Секиз Огуз, Чик хооронд хэд хэдэн мөгөлдөөн гарсан болон 744-750 онуудад хүчирхэгжсэн Уйгурт дагаар орсон эсвэл шахагдсан бусад ард түмнүүдийн талаар дурьдсан байдаг³⁴. Тору Сенга зарим татар өрнөд рүү нүүдэллэсэн гэсэн саналыг дэвшүүлсэн билээ³⁵. VIII зууны сүүл буюу Карлук Огуз нар Уйгураас зааглах, зай барьж эхэлсэн тэр үеэс, Гардизигийн бүтээлтэй танилцах явцад эл санал төрсөн бололтой. Сенга цаашлан Кимекүүдийг Иртыш мөрний хөвөөнд ирэх үед төлөвшсөн бүлэглэл болоогүй байсан гэж үзжээ. Тутуг Шадын дүрээр Кипчак болон бусад зохион байгуулалттай бүлэглэлүүд аль хэдийнээ энд аймгийн холбооны хэлбэрээр [оршиж] байсан (тэд энэ бүс нутагт ирээд удаагүй байсан байж болно)³⁶. Кимек хэмээх этнонимын этимолог болон хэл угсааны хамаарал үл мэдэгдэж байна. Сенгагийн санал бидэнд байгаа зарим мэдээтэй нийцэж, Уйгураас зайлж буй ард түмнүүдийн нүүдэлтэй тохирч, боломжийн тайлбар болохоор байна. Энэ мөчөөс эхлэн олон талаас судлагдаж, мэтгэлзсэн олон бүтээл туурвилд хөндөгдөж буй Кипчакийн угсаа гарлын асуудлыг орхимой, учир нь энэ нь бие даасан судалгаанд хөндөгдөх ёстой юм. Гэсэн хэдий ч Иймек, Иэмэкийн шууд холботой Кимакийн угсаа гарлын асуудлаар цөөн хэдэн үг хэлэх хэрэгтэй юм³⁷.

³² Rashid ad-Din, Jami' at-Tawdrikh ed. M. Raushan and M. Musawi (Tehran, 1373/1994), I, p. 66.

³³ T. Tekin, *Orhon Yszitlan* (Ankara, 1988), pp. 2/3, 9/10. 38/39, 48/49. Kliashtornyi (see S. G. Kliashtornyi, "Das Reich der Tataren in der Zeit vor Cinggis Khan" *Central Asiatic Journal*, 36/1-2 (1992), pp. 72-83 and S. G. Kliashtornyi and T. I. Sultanov, *Gosudarstva i narody evraziiskikh stepei* (Sankt Peierburg, 2000), pp. 128-133, argues for the existence of a number of Tatar "states" in the Pre-Chinggisid era, among them a polity in the East Turkistan-Kansu region in the Uyghur imperial and post Imperial period. The ethnic affiliations of these Tatars, he maintains, were none too clear. However, it is generally held that the Tatar language was Mongolic or some closely related tongue deriving from the same source as Proto-Mongolic. J. Janhunen, *Manchuria. An Ethnic History* (Helsinki, 1996), pp. 146, 159-161, has suggested the useful term "Para-Mongolic" to designate languages stemming from the same source as the Mongolic languages and related to them genetically, but not, strictly speaking, descended from Proto-Mongolic. Qitanic would be one such example. For the Tatar-Uyghur association, see J. R. Hamilton. *Les Ouighours a l'epoque des cinq dynasties d'apres les documents chinois* (Paris, 1955), pp. 138. 155: Sir Harold Bailey, *Indo-Scythian Studies being Khotanese Texts VII* (Cambridge, 1985), pp. 92-94.

³⁴ See text in Moriyasu and Ochir. *Provisional Report*, pp. 178-186.

³⁵ Senga, "Megjegyzesek" AT. XLI/1-2 (1997), pp. 187-188.

³⁶ Senga, "Megjegyzesek" AT, XLI/1-2 (1997), pp. 188-190. Kumekov, *Gosudarstvo*, p. 114, in contrast, viewed the Tatars as joining the Kimek union only after the fall of the Uyghur Qaghanate in 840.

³⁷ In addition to Marquart, *Komanen*, see O. Pritsak. "The Polovcians and rus" *Archivum Eurasiae Medii Aevi*, 2 (1982). esp. pp. 320-336 and S. G. Kliashtornyi, "Kypchaki v runicheskiikh pamyatnikakh" *Turcologica* 1986

Кимакийн угсаа гарал

Тэд өөрсдийн хамжилгат болон эрхшээлд нь орж байсан Кипчакийн нэгэн адил өөр өөр цаг үед тухайн бүс нутагт Монгол, Түрэг болон Дотоод Азийн бусад ард түмнүүдийн оролцоотой, янз бүрийн аймгийн бүлэглэлүүд цогцос холимоогоос гаралтай хэмээн Кимекийг авч үзэж болно. Жишээлбэл, Аль Ма'судын тэмдэглэлд Хар, Цагаан Иртышийг "Уйгурын Кимек орон" гэж өгүүлсэн байдаг. Тэд Жайхун (Трансоксан) Балх голын цаад нутгийн түрэг аймаг гэжээ³⁸. Урт хугацааны турш Кипчакийн дунд гардаг Уйгур/Уугур этнонимыг Ийгурыг/"Yigur" Уйгурын/Уугур нэг хэлбэр гэж үзэж байв³⁹. 840 онд Монголын нутагт төр нь мөхөж, өрнөд рүү нүүдэллэсэн уйгурууд Кимакт шингэжээ.

Кимакийн угсаа гарвалын талаар дэвшүүлсэн хэд хэдэн онол байдаг. Жозеф Маркуарт, өөрийнхөө мэтгээ маягаар хийсэн дүгнэлтэндээ Кимекийг VIII зууны эхэн үеэр "ард түмэн" болж нэгдсэн гэжээ. Тэдний угсаа гарвалыг татарын дундаас олж болно. Тэднийг тэрбээр эртний түрэг сударт Монгол гэгддэг ард түмэн буюу шинжлэх ухаанд сүүлийн үед нэвтэрч буй томъёогоор "Монгол төстэй [*Para-Mongolic*]" татабитай холбожээ. Түүний тооцоолж байгаагаар VII зууны тохиосон нэгэн аюулын үр дүнд эдгээр ард түмэн Өрнө зүгт нүүдэлсэн аж. Тэгвэл Ким-күүдийг түрэгжсэн бүлэг татар гэж үзэх хэрэгтэй юм⁴⁰.

Омелжан Прицак тэднийг Хүннү бүлэглэл⁴¹ хятад сурвалжийн *Кумоси /K'u-mo Hsi* угсаа гаралтай гэж заажээ. *Кумо/K'u-mo* [Дундад Хятад *k'uo-mak* үүнийг Прицак Монгол *Quomegh*] мөн *Cu/Hsi* [Дундад Хятадын *ghiei= Ghay/Qay*] эртний түрэг бичээс дээр *tatabu/tatabi* нараас бүрдсэн гэж⁴², түрэг *кимек/kimek* хэлбэр нь Алтай хэлний *Quomegh*-аас үүсэлтэй гэжээ. Тэрбээр *Quomagh* нь яаж *кимек/kimek* болсоныг тайлбарлаагүй, боловч дамжсан хэлбэрээр (аль Бурунигийн тэмдэглэсэн) Кумакийг заажээ. Мөн түүнчлэн "1517 онд Масиеж Миековитагийн [*Macie Miechowita*] Сармаатын трактат "*Tractatus duobus Sarmatiis*" Кумани-ийн Кимовегийн бүдүүлэг дуудлага [*Cumani dicti vulgariter Cimove*"] гэж тэмдэглэж, "*Kimow<Kimagh* нь "*Quomagh*"-ын хэлбэр байх магадлалтай" гэж үзжээ⁴³. Кипчакийн *gh>w* (жишээлбэл: *tagh* "уул" *taw*) болж өөрчлөгдсөнийг олноо сайн мэдэх юм. Гэсэн хэдий ч эл хэлбэр *Quimagh* байх ёстой юм. Мөн түүнчлэн, тагнайн хойд хэсгээс яаж тагнайруу буюу *u-аас >i* у-руу шилжсэн тухай тайлбар алга байна. Цашилбал Слав хэлний Ким нэртэй ард түмнийг "*Kimove(Cimove)*" төлөөлж байх боломжтой юм. Товчоор хэлбэл, "Кимове"-г Кимектай холбосон нь төсөөлөл төдий юм.

(Leningrad, 1986), pp. 153-164, where he identifies them with the Sir of the Orkhon inscriptions; S. M. Akhinzhanov. *Кыпчак и истории средневекового Казахстана* (Алма-Ата, 1989).

³⁸ Al-Mas'udi. *Muruj adh-Dhahab wa Ma'adin al-Jawhar*, ed. Ch. Pellat (Beirut, 1966-1979), I, p. 116.

³⁹ On the latter, see Golden. "Cumanica IV" *АЕМАе*. 9 (1995-1997), p.121.

⁴⁰ Marquart. *Komanen*, pp. 95-96.

⁴¹ A tribal grouping of presumed Pre-Proto-Mongolic and Pre-Para-Mongolic speakers, Janhunen, *Manchuria*, p. 187. For the Chinese accounts, see J. L. M. Mullie, "Les Sien-pi" *Central Asiatic Journal* 13 (1969), pp. 24-51 and V. S. Taskin. *Materialy po istorii drevnikh kochevykh narodov gruppy dunkhu* (Moskva, 1984). esp. pp. 70ff

⁴² Turk Tatabi = Tibetan *Dad-pyi*, the same Tibetan ms. also notes the *He=Chin*. *Hsi* [*Ghie/Qay*], see J. Bacot. "Reconnaissance en Haute Asie septentrionale par cinq envoyes ouigours au VIIIe siecle" *Journal Asiatique*, 244 (1956), pp. 141, 145 "the tribe called He by the Tibetans, He-ce by the Chinese, Dad-pyi by the Turks (Drugu)".

⁴³ Pritsak, "The Polovcians and Rus" *АЕМАе*, II (1982), pp. 331-333, See also P. Pelliot, "A propos des Comans" *Journal Asiatique*. 15(1920), p. 150n. 2. who is inclined to read the joined name *K'u-mo Hsi* as *Qumaghai*. See also P. B. Golden, "Cumanica II: The Olberili (Olperli): The Fortunes and Misfortunes of an Inner Asian Nomadic Clan" *Arhivum Eurasiae Medii Aevi*. 6 (1986 [1988]). pp. 15- 22

Казахийн түүхч Булат Кумеков өөрийн зүгээс, хятад судлаач А.Зуевын судалгаа дээр хэсэгчлэн үндэслэн хятад сурвалжийн *Иен-мо/ Yen-mo* [Дундад Хятад *патак*⁴⁴, Иен миен/*Yen mien*-ээс⁴⁵ ялгасан хэлбэр байж болох талтай] Измэк/*Yemek* байна гэжээ. *Tue-le/Tieh-le* аймаг Баруун хойт Монгол (Ховд голын сав газар) нутаглаж байсан ба VII зууны дунд үед Баруун Түрэгийн хаант улсын нэг хэсэг, Иртыш мөрний сав газар амьдарч байжээ. 656 онд Түрэгүүд унасны дараа тэд туурга тусдаа шинэ бүрдэл, Кимекийг бүрдүүлж, удалгүй бусад аймгуудыг, нэн ялангуяа 840 онд Уйгурын улс мөхсөний дараа Татар болон Уйгур [*Uyghur/Yughur*] бүлэглэлүүдийг чиглүүлэн татжээ. Товчоор хэлбэл, тэрбээр Кимекийн төр IX зууны хоёрдугаар хагас хүртэл төлөвшиж, хэлбэржээгүй байсан гэж үзжээ⁴⁶.

Дараа нь өөр нэг Казакийн түүхч Сержан Ахинжанов Кимак, Кипчакийн угсаа гарвал, ялгаатай үндсийг холбох гэж оролджээ. Тэрбээр тэр хоёрыг болгоомжтой ялгажээ. Тамим б.Баарын (820 оноос хойш) тэмдэглэлийг дагаж Кимекийн нутаглаж байсан газруудыг Уйгурын зүүн хойно⁴⁷, өөрөөр хэлбэл, Хойт, зүүн Монгол болон Баруун Манжуурын хил залгаа тал нутагт байршуулжээ. Кумеков "*Кумек-Кимек-Кумоси*" холбоосыг хүлээн зөвшөөрч, Рашид ад-Дины тэмдэглэсэн Уйгурын *Кумуг Ами Күз* [*Qumuq Ati Kuz? Qmq ati kuz*] аймагтай адилсган тодорхойлжээ⁴⁸. Энэ нь хэл зүйн хувьд нийцэхгүй байгаа юм. Үүнтэй тулгарсны дараа тэрбээр Тамим б.Баарыг "Кумук" [*Qumuq*] ард түмнийг "Кимек" гэж андуу нэрлэсэн байж болох бөгөөд үүнээс араб зохиолд уламжлагдсан гэж үзжээ. Дараа нь тэрбээр, Кимекийг Сүнүү *Hsieh-yen-to*, Түрэг, Уйгурын бүрэлдэхүүнд байсны үр дүнд хэсэгчлэн түрэгжсэн Монгол төст *Кай* [*Qay*]-тай адилсган авч үзжээ⁴⁹. Ахинжанов, Кимакуудыг өрнөд рүү VIII-IX зууны эхэнд нүүдэл хэд хэдэн үе шаттай явагдаж, Уйгурын хаант улс мөхөл, тарваган тахал ба цаг уурын өөрчлөлт зэргээс эрчтэй явагдсан гэж үзжээ. Сүүлийн давалгааг тэрбээр *Кай* [*Kai*]-тай холбож (түүний галигаар *Kai* гэхээс илүү *Qayi* байх ёстой, мэдээж хэрэг эдгээр хоёр маш их ялгаатай бүлэглэл хожим, Огузын холбооны нэгэн аймаг болжээ⁵⁰) Манжуурт хөршүүдтэйгээ үргэлж дайтаж байгаад тэд нар 847 онд өрнөд рүү нүүдэллэжээ. Кимек нь номны зохиомол нэр гэж тэрбээр үзжээ. "Кай" нь өөр нэрний тасархай, уг нэрний үндэс Уриан [*Uran*] бөгөөд зүүн Казакстанд амьдарч байсан Кипчак ба Измэкээс авсан гэжээ. *Уриан ба Кай*[*хай*] "*могой*" гэсэн үгнээс гаралтай (Ахинжанов Монгол хэлний "могой" гэсэн үгийг авсан бололтой). Мэдээж хэрэг, Кумоси ба *Уранкай/ Уранхай* гэдэг нэрийг нь бид биднэ. Тэд Иртыш мөрөн ба Алтайн бүс нутагт IX зуунд гарч ирж, XI зуун гэхэд түрэгжжээ. Энэ үеэр Кипчакууд ноёлох элемент болсон гэжээ⁵¹. Үүний ихэнх нь зохиомол зүйл болой.

Сергей Кляшторный цуврал өгүүлэл, хэд хэдэн номондоо Түрэг бичээсийн Сир[*Sir*]-ийг Кипчактай адилсган үзжээ. Тэрбээр Шинэ усны бичээсийн *түрэг кипчак* [*turk qibchaq*]-ийг нөхөн сэргээсэн бичээсийг бүрэн хүлээн зөвшөөрч, харин "түрэг ба

⁴⁴ See L. Hambis. "Katim et Gus-dum" *Journal Asiatique*, 3 (1958). p. 318, 320; Akhinzhanov. *Кыпчак*. pp. 46-47, Hambis reconstructs the form Yen-mo-nien-tu-liu chiu-ch'i-chin as *Yamak namturlug kul erkin*. i. e. Nam-turlug. the *kul erkin* of the Yemek. He also cites *a-ma* as the Tibetan rendering of this name. They are beyond the *Drugu* (Turk-Uyghurs). The form *-Yamak nam* he views as "bien invraisemblable en turc." The Yen-mo, in the *T'ung-tien* and other Chinese sources, are some 30 days from the Turgish, according to a notice going back to ca. 652

⁴⁵ See Chavannes. *Documents*, pp. 68. n. 76n., 122n. 123n., 272, 280-281 and C. Beckwith. *The Tibetan Empire in Central Asia* (Princeton. 1987). p. 75n. 117.

⁴⁶ Kumekov. *Gosudarstvo*. pp. 46-47, see also *Istoriia Kazakhstana*, I, p. 322.

⁴⁷ Tamim/Minorsky, pp. 281/284.

⁴⁸ Rashid ad-Din, ed. Raushan and Musawi. I, p. 139.

⁴⁹ Akhinzhanov. *Кыпчак*. pp. 100-114.

⁵⁰ See M. F. Koprulu. "Osmanli imparatorlugu'nun Etnik Mensei Mes'eleleri" *Belleten*. VII (1944), pp. 219-303.

⁵¹ Akhinzhanov. *Кыпчак*. pp. 143-146; Sumer, *Oguzlar*. pp. 216-221.

кипчак" гэж тайлбарлаж байгаа юм⁵². Отүгэн бүс нутгаас Уйгурт шахагдсан Сир/Кипчак ба түрэгүүд Умард Алтай ба дээд Иртышт төвлөрчээ. Тэнд шинэ аймгийн холбоо хэлбэрээ олж эхэлснийг [ач холбогдолыг] бууруулан авч үзэж, түрэгийн эзэнт гүрний үед татарууд улс төрийн нэгдэл дутагдалтай, том бөгөөд тогтворгүй бүлэглэл байсан гэж үзжээ.

Энэ нь отуз татар ("гучин татаар"), токуз татар ("есөн татаар") г.м. нэр томьёонд тусгагдаж, тэдний аймгийн холбооны бүрэлдэхүүнд гарч буй өөрчлөлтүүдийг цохон тэмдэглэжээ. Үүнээс гадна, олон түрэг хүмүүс өөрсдийгөө татар гэж нэрлэж байсан гэж үзжээ. "Тийм учраас, Кимекийн хүй нэгдэл бүрэлдэх үйл явцын эхэн үеийг монгол хэлтэн аймагтай заавал холбох шаардлагагүй, VIII зуунд Иртышийн бүс нутагт татарууд гарч ирсэн явдал зүүн Монголоос нүүдэллэсэн гэсэн үг биш" гэж дүгнэжээ⁵³. Кимекийн холбоо бүрэлдэх явц нэлээд төвөгтэй бөгөөд Уйгурын улс мөхсөний дараа дүрэвсэн Токуз Огузыг хэлтэрхийнүүд оролцсон байх ёстой. Энэ үеэр (840 оноос хойш), Кимекийн удирдагч хааны хэргэм авч Карлук ба Киргиз хаадтай эн тэнцүү болохоо илэрхийлсэн юм⁵⁴. Миний бодлоор, татар элементийг ийнхүү хялбар зайлуулж үл боломой. Талын ертөнцөд, заримдаа эрхшээлд нь байсан, эсвэл дагаар орсон ард түмнүүд ноёлох овог эсвэл аймгийн этнонимыг авсан нь улс төрийн хувьд хүлээн зөвшөөрсний илэрхийлэл болдог⁵⁵. Татарууд эл түүхэн үед ийм тавилангүй байжээ. Тэд нар сайндаа л Түрэгийн хаант улсын үе үе бослого гаргадаг хараат байсан байна. Чингисийн Монголчуудын эрин үеэс өмнө буюу XII зууны хоёрдугаар хагаст Дотоод Азийн дорнод хэсэгт чухал хүч болсон юм⁵⁶. Тэр үед (Кимекийн холбоо бүрдсний дараа) тэдний нэр бусдад тархсаныг бид Рашид ад-Динаас судласан бөлгөө⁵⁷. Татарын төлөөлөл бодит бөгөөд Баруун Сибирийн аймгуудын холбоонд Монгол Манжуурын хил хавийн нутгийн элемент төлөөлөл түгээмэл зүйл биш юм.

Тору Сенга Кимекийн холбоог нягтлан авч үзэхдээ Иэмэкийг *Иен-мо*-той адилсгаж, тэднийг Ховдод Кемчик голын өмнө зүгт нутагтай байсан гэж хүлээн зөвшөөрчээ. Түрэгийн засаглал (630 оноос өмнө) ба Хятадын эрхшээлийн дараах үед буюу 680-иад оны эхэн үед тэд Баруун Сибирьт нүүдэллэжээ. 700 оны үед тэд нар "эрлийз морьтон ард түмнүүдийн" [*Ala Yundlugh*] хөрш зэргэлдээ байсан байна. 744 онд Монголд шийдвэрлэх хүчин болсоны дараа Уйгурын дарамт дор нүүдэллэх үйл явц шувтарчээ⁵⁸. Иртышийн бүс нутагт Татар ба Кипчактай нэгдснээр VIII зууны дунд үер Кимекийн холбооны хэлбэр бүрэлдэн төлөвшсөн байна. Кимекууд эрлийз морьтон ард түмнүүдийн (тэрбээр тэднийг Финн угор хүмүүс байсан гэж үзэж байв⁵⁹) газрыг эрхшээлдээ оруулан авчээ. Ийнхүү кимекийн холбоо байгуулагдахдаа Монгол, Түрэг ба Финн-угор элементээс бүрджээ. Кимекийн холбоо бүрдсний дараа татар ба кипчакууд VIII зуунд нэгдсэн байна⁶⁰. Сенгагийн санааг Кимек>Иймэк>Иймэк томьёолол зовоож байжээ. Тэрбээр *ki>i* шилжилтийг Кимекийн нэгдэл бүрэлдсний дараа бий болсон гэж үзэж, *Кимек/kimek* ба *Иамак/Иймэк* [*Yamek/(Y)imek*] нэр нь өөр өөр нутгийн аялгуу байсан байж болох юм гэжээ. Мөн түүнчлэн, хэлний адилсалын

⁵² Kliashtornyi, "Kipchaki v runicheskikh pamiatnikakh" *Turcologica* 1986. pp. 153-164 and most recently in Kliashtornyi and Sultanov, *Gosudarstva*, pp. 110-118.

⁵³ Kliashtornyi, Sultanov, *Gosudarstva*, pp. 118-119.

⁵⁴ Kliashtornyi, Sultanov. *Gosudarstva*, pp. 119-120.

⁵⁵ Gy. Nemeth. *A honfoglalo magyarsag kialakulasa* (2nd ed., Budapest, 1991), pp. 84, 104-108.

⁵⁶ P. B. Golden, "Tatar" *Encyclopaedia of Islam*, 2nd ed. (Leiden, 1960), fasc. X, pp. 370-371; L. N. Gumilev, *Drevnie turki* (Moskva, 1967). pp. 31, 137; P. Pelliot, L. Hambis, *Histoire des campagnes de Gengis Khan* (Leiden, 1951). I, pp. 2ff. Marquart, *Komanen*, pp. 95-96.

⁵⁷ Rashid ad-Din, *Jami' at-Tawarikh*, ed. Rawshan and Musawi. I, pp.41-44.

⁵⁸ Senga. "Megjegyiesefc," AT, XLI/1-2 (1997), pp. 177-181.

